

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч /цаашид “ВХҮҮ” гэх/-ийн зохистой засаглал, үйл ажиллагаа, өөрийн хөрөнгийн хэмжээ, тайлан мэдээнд тавигдах шаардлагыг тодорхойлоход оршино.

1.2. ВХҮҮ нь “Компанийн засаглалын кодекс” болон түүнд нийцүүлсэн дүрэм, журам, заавар аргачлалыг үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.

1.3. ВХҮҮ нь харилцагчийн эрх ашгийг хамгаалах, виртуал хөрөнгийн зах зээлийн шударга өрсөлдөөнийг хангаж ажиллана.

Хоёр. Виртуал хөрөнгийг арилжих үйл ажиллагаа

2.1. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 6.1.1, 6.1.2-т заасан үйл ажиллагааг эрхлэхэд тус бүлэгт заасан шаардлагыг хангаж ажиллана.

2.2. ВХҮҮ нь харилцагчийн мөнгөн хөрөнгийг буцаан шилжүүлэхэд банкны шимтгэлээс бусад аливаа шимтгэл авахгүй байна.

2.3. ВХҮҮ нь харилцагчийн захиалгыг үнэ, цаг хугацааны дарааллын дагуу арилжааг шударгаар зохион байгуулна.

2.4. ВХҮҮ нь арилжааны талаарх мэдээ, мэдээллийг үнэн, зөв гаргаж нийтэд мэдээлнэ.

2.5. ВХҮҮ нь виртуал хөрөнгийн үнэ ханшид нөлөөлөх, нийтийн хүртээл болоогүй мэдээллийг ашиглаж арилжаанд оролцох, үнэ ханшийг зохиомлоор тогтоох, хуурамч арилжаа хийх, мөн хууран мэхлэх зорилгоор оролцогч, харилцагчийг арилжаанд оролцуулах, эсхүл оролцуулахгүй байхад урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах захиалга, хэлцэлд дотоод хяналт, шалгалтыг тогтмол хэрэгжүүлнэ:

2.5.1. их хэмжээний хэлцэл тус бүрийг;

2.5.2. үнэ ханшийн өсөлт, бууралт ихтэй арилжааг;

2.5.3. виртуал хөрөнгийн үнэ ханшид нөлөөлөхүйц 2 ба түүнээс дээш удаа цөөн тоо ширхгээр виртуал хөрөнгө худалдсан, худалдан авсан хэлцлийг;

2.5.4. холбогдох болон нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн хооронд 5 ба түүнээс дээш удаа хийгдсэн виртуал хөрөнгийн арилжааг;

2.5.5. сэжигтэй гэж үзсэн бусад.

2.6. ВХҮҮ нь энэ журмын 2.5-д заасан нөхцөл илрүүлсэн тохиолдолд Хороо, хууль хяналтын байгууллагад 24 цагийн дотор нотлох баримтын хамт хүргүүлнэ.

2.7. Виртуал хөрөнгийн арилжааны хэлцэл биелсний дараа бодит цагийн горимоор дор дурдсан мэдээллийг оролцогчид авах боломжтой байх:

- 2.7.1. виртуал хөрөнгийн нэр;
- 2.7.2. хэлцэл биелсэн хугацаа;
- 2.7.3. арилжсан виртуал хөрөнгийн хэмжээ;
- 2.7.4. бусад шаардлагатай мэдээлэл.

2.8. ВХҮҮ нь дараах арга хэрэгслээр арилжааг зохион байгуулах боломжтой байх:

- 2.8.1. зах зээлийн үнийн арга (market order);
- 2.8.2. нөхцөлт захиалгын арга (limit order);
- 2.8.3. бусад арга хэрэгсэл.

2.9. ВХҮҮ нь арилжаанаас хассан виртуал хөрөнгийн мэдээллийг Хороонд 24 цагийн дотор хүргүүлнэ.

Гурав. Виртуал хөрөнгийг шилжүүлэх үйл ажиллагаа

3.1. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д үйл ажиллагааг эрхлэхэд тус бүлэгт заасан шаардлагыг хангаж ажиллана.

3.2. ВХҮҮ нь нэг удаагийн болон 24 цагт хийсэн хэд хэдэн арилжааны нийлбэр дүн 3.00 сая төгрөг болон түүнээс дээш мөнгөн хөрөнгө, виртуал хөрөнгийн гүйлгээг шилжүүлэхэд дараах мэдээллийг авсан байна:

- 3.2.1. шилжүүлэгчийн овог нэр /хуулийн этгээдийн нэр;
- 3.2.2. шилжүүлэгчийн блокчэйн хаяг, нийтийн түлхүүр;
- 3.2.3. шилжүүлэгчийн оршин суугаа хаяг;
- 3.2.4. шилжүүлэгчийн албан ёсны баримт бичиг/иргэний үнэмлэх;
- 3.2.5. шилжүүлэгчийн дансны дугаар;
- 3.2.6. виртуал хөрөнгийн төрөл хэлбэр болон шилжүүлэх хөрөнгийн хэмжээ;
- 3.2.7. хүлээн авагчийг тодорхойлох;
- 3.2.8. хүлээн авагчийн нэр;
- 3.2.9. хүлээн авагчийн блокчэйн хаяг эсвэл дансны дугаар;
- 3.2.10. бусад нэмэлт мэдээлэл шаардаж болно.

3.3. ВХҮҮ нь харилцагчийн хийсэн шилжүүлэг бүрд бодит цагийн горимоор хяналт тавина.

3.4. ВХҮҮ нь зөвхөн харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг ВХҮҮ-ийн дансанд шилжүүлэг хийнэ.

Дөрөв. Виртуал хөрөнгө, түүнд хамаарах хэрэгслийг хадгалах, удирдах

4.1. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-д үйл ажиллагааг эрхлэхэд тус бүлэгт заасан шаардлагыг хангаж ажиллана.

4.2. ВХҮҮ нь өөрийн хөрөнгийг 30 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй виртуал хөрөнгийг хадгалж, удирдана.

4.3. ВХҮҮ өөрийн хөрөнгийн хэмжээний шалгуурыг улирал тутам тооцож, энэ журмын 4.2-т заасан шаардлагыг хангаж ажиллана.

4.4. ВХҮҮ нь харилцагчийн хөрөнгийг хадгалахдаа харилцагч бүрийн хөрөнгийг тус тусад нь хадгална.

4.5. Виртуал хөрөнгийн 95-аас доошгүй хувийг бодитоор /cold wallet/, 5-оос дээшгүй хувийг цахим /hot wallet/ хэлбэрээр хадгалдаг байна.

4.6. ВХҮҮ нь удирдаж буй виртуал хөрөнгийн үлдэгдэл, ханш, шилжүүлэгийн мэдээллийг харилцагчид улирал бүр хүргүүлнэ.

Тав. Виртуал хөрөнгийг нийтэд санал болгох, худалдахтай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах, санхүүгийн үйл ажиллагаанд оролцох болон үйлчилгээ үзүүлэх

5.1. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5-д үйл ажиллагааг эрхлэхэд тус бүлэгт заасан шаардлагыг хангаж ажиллана.

5.2. Дотоодын виртуал хөрөнгө арилжаалахаас өмнө тухайн виртуал хөрөнгө гаргагчтай хамтын ажиллагааны гэрээ байгуулсан байна.

5.3. ВХҮҮ нь виртуал хөрөнгө гаргагчийн виртуал хөрөнгийг нийтэд санал болгох, худалдахтай холбоотой ажлыг зохион байгуулахаас өмнө дараах асуудлыг магадлан шинжилсэн байх:

5.3.1. виртуал хөрөнгө, түүний төсөл нь эдийн засгийн үр ашигтай, бодиттой, урт хугацаанд тогтвортой хэрэгжихүйц эсэх;

5.3.2. виртуал хөрөнгө гаргагч, түүний эцсийн өмчлөгч, эрх бүхий албан тушаалтан нь эдийн засгийн гэмт хэрэгт холбогдож байгаагүй, хугацаа хэтэрсэн өр зээлгүй, бизнесийн нэр хүндтэй, мэргэжлийн багтай эсэх;

5.3.3. виртуал хөрөнгийн суурилсан систем, технологи нь бүрэн хөгжүүлэлт хийгдэж, кибер аюулгүй байдлыг хангасан эсэх;

5.3.4. бусад асуудал.

5.4. Виртуал хөрөнгийн танилцуулгад дор дурдсан мэдээллийг тусгасан байна:

- 5.4.1. танилцуулга нь монгол хэл дээр бичигдсэн байх;
- 5.4.2. виртуал хөрөнгийн хэрэглээ, гаргаж буй зорилго, блокчэйний төрөл;
- 5.4.3. виртуал хөрөнгийн смарт контрактын анхны хаяг;
- 5.4.4. виртуал хөрөнгө гаргагчийн оноосон нэр, оршин байгаа газрын шуудангийн болон холбоо барих хаяг, эрхэлж байгаа үйл ажиллагааны талаар;
- 5.4.5. виртуал хөрөнгө гаргагчийн хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл, эзэмшиж байгаа хувьцааны тоо, хувь хэмжээ;
- 5.4.6. виртуал хөрөнгө гаргагчийн бүтэц, зохион байгуулалт, эрх бүхий албан тушаалтны нэр, зураг, ажлын туршлага, тэдгээрийн эзэмшиж буй хуулийн этгээдийн хувьцааны тоо, хэмжээ болон бусад нэмэлт мэдээлэл;
- 5.4.7. виртуал хөрөнгө гаргагчийн санхүүгийн тайлан, түүний талаар аудитын байгууллагаас гаргасан дүгнэлт;
- 5.4.8. нийтэд санал болгох виртуал хөрөнгийн тоо хэмжээ, санал болгох үнэ;
- 5.4.9. татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагааны төлөвлөгөө;
- 5.4.10. виртуал хөрөнгийн хуваарилалт, тархалтын мэдээлэл;
- 5.4.11. виртуал хөрөнгө гаргагчийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийн талаарх мэдээлэл;
- 5.4.12. виртуал хөрөнгийн смарт контрактын аудитын дүгнэлт;
- 5.4.13. бусад мэдээлэл.

5.5. ВХҮҮ нь шинээр арилжаалах виртуал хөрөнгийн танилцуулга, холбогдох баримт мэдээллийг нийтэд санал болгож худалдах ажиллагааг зохион байгуулахаас өмнө Хороонд ажлын 10 хоногийн дотор хүргүүлнэ.

5.6. ВХҮҮ нь виртуал хөрөнгийн танилцуулга, токеномикс, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, эрсдэлийг бууруулах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх боломжоор хангагдсан байна.

Зургаа. Мэдээллийн ил тод байдал, харилцагчийн эрх ашгийг хамгаалах

6.1. ВХҮҮ нь дараах мэдээллийг өөрийн програм хангамж болон цахим хуудсанд ил тод, нээлттэйгээр байршуулна:

- 6.1.1. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 9.1.1-9.1.13, 10.13-д заасан мэдээллийг;
- 6.1.2. арилжааны програм хангамжийг ашиглахтай холбоотой заавар, зөвлөмж, гарын авлагыг;

6.1.3. олон нийттэй харилцах холбоо барих утас, цахим шуудан, олон нийтийн сүлжээг идэвхтэй ажлуулж, үйл ажиллагаа явуулж буй хаяг, байршил, холбоо барих утсыг үнэн, зөв мэдээлж байх;

6.1.4. өөрийн програм хангамжаар дамжуулан арилжиж буй дотоодын нийтэд санал болгон, худалдсан виртуал хөрөнгийн танилцуулга;

6.1.5. бүтээгдэхүүн, үйлчилгээний шимтгэл хураамжийн талаарх мэдээлэл;

6.1.6. виртуал хөрөнгийн төвлөрсөн бус сүлжээ дэх бүртгэлийн дугаар, ялгах тэмдэг, нийт гаргасан болон арилжиж буй тоо ширхэг, үнэлгээ, ханш, арилжааны хэмжээ;

6.1.7. виртуал хөрөнгийн бүртгэлийн шаардлага, шалгуур, дүрэм, журам;

6.1.8. харилцагчтай байгуулах гэрээ, түүнд тавигдах шаардлага;

6.1.9. хэрэглэгчдийн санал, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх ажиллагааны талаарх мэдээлэл;

6.1.10. ВХҮҮ-ийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, бизнест шууд нөлөө үзүүлэхүйц хэлцэлийн талаар;

6.1.11. ВХҮҮ төлбөрийн чадваргүй болох, эсхүл татан буулгах шийдвэр гаргасан, шүүхээс ВХҮҮ-тэй холбоотойгоор дампуурлын хэрэг үүсгэсэн;

6.1.12. үйл ажиллагаанд ашиглах програм хангамж, систем болон мэдээлэл, технологийн өөрчлөлт, шинэчлэлтийн талаар;

6.1.13. үйл ажиллагааг хязгаарласан, түр зогсоосон, эсхүл бүртгэлээс хасагдсан.

6.1.14. ВХҮҮ нь виртуал хөрөнгийн арилжааг урвуулан ашиглахаас сэргийлэх зорилгоор дараах мэдээллийг тогтмол, эсхүл тухай бүр програм хангамж болон цахим хуудсанд ил тод, нээлттэйгээр урьдчилан байршуулж, олон нийтэд мэдээлнэ:

6.1.14.1. арилжааны програм хангамж дахь виртуал хөрөнгийн үнэ ханш нь олон улсын зах зээл дээрх дундаж үнээс харьцангуй доогуур, эсвэл дээгүүр байх тохиолдолд үнийн зөрүүг тогтворжуулан хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор хийж буй тухайн ВХҮҮ-ийн арилжааны талаар;

6.1.14.2. нийтэд санал болгон виртуал хөрөнгө гаргагч нь тухайн виртуал хөрөнгийн үнэ ханшийг огцом унахаас сэргийлэх зорилгоор ВХҮҮ-тэй тохиролцож, холбогдох гэрээ байгуулсны үндсэн дээр өөрөө эргүүлэн худалдан авах ажиллагааны талаар.

6.1.15. өөрийн програм хангамжаар дамжуулан нийтэд санал болгон, худалдсан виртуал хөрөнгө гаргагчийн үйл ажиллагааны дараах өөрчлөлтийн талаарх мэдээллийг авч тухай бүр мэдээлдэг байх:

6.1.15.1. эрх бүхий албан тушаалтны өөрчлөлт;

6.1.15.2. үйл ажиллагаанд нь хүндрэл үүссэн;

6.1.15.3. виртуал хөрөнгийн танилцуулга, токеномикс, үйл ажиллагааны төлөвлөгөөний өөрчлөлт, тэдгээрийн гүйцэтгэл буурсан;

6.1.15.4. бүтэц зохион байгуулалтад орсон өөрчлөлт;

6.1.15.5. эрх бүхий албан тушаалтан, ажилтан эдийн засгийн гэмт хэрэгт холбогдсон;

6.1.15.6. ВХҮҮ-ийн үйл ажиллагааны дотоод журамд заасан бусад мэдээлэл.

6.1.15.7. бусад мэдээлэл.

6.2. ВХҮҮ нь харилцагчийн эрх ашгийг хамгаалах үйл ажиллагааны хүрээнд дараах шаардлагыг хангаж ажиллана:

6.2.1. харилцагчийн өргөдөл, гомдлын бүртгэл хөтөлж, хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор хариу хүргүүлэх;

6.2.2. харилцагч, олон нийтийн виртуал хөрөнгийн эрсдэлийн талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн ажлыг улирал бүр зохион байгуулах;

6.2.3. харилцагчийн мэдээллийг эрх бүхий байгууллагаас бусад этгээдэд харилцагчийн зөвшөөрөлгүй мэдээлэхгүй байх.

Долоо. Мэдээлэл, тайлагнал

7.1. ВХҮҮ нь хууль тогтоомж, энэхүү журамд заасан мэдээллийг бүрэн гүйцэд, үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүйгээр тогтоосон хугацаа болон тухай бүрд харилцагч, олон нийтэд мэдээлэх, Хороонд хүргүүлж тайлагнана.

7.2. ВХҮҮ нь жилийн санхүүгийн тайланг дараа жилийн 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор, хагас жил, улирлын санхүүгийн тайланг дараа сарын 20-ны өдрийн дотор Хороонд тогтмол хүргүүлнэ.

7.3. ВХҮҮ нь аудитын хуулийн этгээдээр баталгаажуулсан жилийн санхүүгийн тайлан, дүгнэлтийг дараа жилийн 5 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хороонд ирүүлнэ.

7.4. ВХҮҮ нь дараах мэдээллийг агуулсан үйл ажиллагааны жилийн тайланг дараа жилийн 3 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хороонд тогтмол ирүүлж, олон нийтэд мэдээлнэ:

7.4.1. тайлант жилд ВХҮҮ-ийн орлогод нөлөөлсөн хүчин зүйлсийг тодорхойлж, дүгнэсэн байх;

7.4.2. ВХҮҮ өөрийн санхүүгийн нөөцөөр бизнесийн үйл ажиллагаанаас бий болсон өр төлбөрийг бүрэн хариуцах боломж, шаардлагатай тохиолдолд гадаад, дотоод эх үүсвэрээс санхүүжилт татах боломжтой талаар;

7.4.3. ВХҮҮ-ийн үйл ажиллагаа явуулж буй салбарын зах зээлийн нөхцөл байдлын судалгаа, эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний шинэчлэл, төрөлжилт, өөрчлөлтийн талаар;

7.4.4. ВХҮҮ-ийн хадгалж, удирдаж байгаа харилцагчдын виртуал болон мөнгөн хөрөнгийн тоон үзүүлэлт;

7.4.5. ВХҮҮ-ийн ашиглаж буй програм хангамж, систем, мэдээлэл, технологийн дэд бүтцийн тасралтгүй, найдвартай ажиллагаа, нууцлал, аюулгүй байдалд хийлгэсэн эрсдэлийн үнэлгээний дүгнэлт, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар;

7.4.6. ВХҮҮ-ийн хийсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл, тухайн хэлцэлд оролцогч талуудын талаар;

7.4.7. ВХҮҮ-ийн эрсдэлийн удирдлагын хэрэгжилт, дотоод аудитын ажлын тайлан;

7.4.8. бусад мэдээлэл.

7.5. ВХҮҮ нь оноосон нэр, хаяг, байршил болон холбогдох этгээдээс бусад хувьцаа эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд компанийн дүрэм, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ажлын 5 өдрийн дотор Хороонд ирүүлнэ.

7.6. ВХҮҮ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, холбогдох этгээд болон эрх бүхий албан тушаалтны өөрчлөлтийг урьдчилан энэхүү журмын нэгдүгээр хавсралт , хоёрдугаар хавсралтын дагуу баримт бичгийг бүрдүүлж, Хороонд хүсэлт гарган шийдвэрлүүлнэ.

7.7. Хороо энэхүү журмын 7.6-д заасан хүсэлтийг зохих шаардлага хангасан, бүрдэл бүрэн баримт бичгийг ирүүлснээс хойш ажлын 20 өдрийн дотор хянаж, шийдвэрлэнэ.

---oOo---

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны ... сарын ...-ны өдрийн ... дугаар тогтоолоор баталсан “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журам”-ын нэгдүгээр хавсралт

ВХҮҮ-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, холбогдох этгээд болон эрх бүхий албан тушаалтанд өөрчлөлт оруулах тухай өргөдөлд хавсаргах баримт бичиг

№	Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт	Хуудасны тоо
1	Энэ журмын хоёрдугаар хавсралт дахь өргөдөл	
2	Өөрчлөлт оруулах эрх зүйн үндэслэл болсон нотлох баримт бичиг, шийдвэр	
3	Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийн шалгуур хангасныг тодорхойлох баримт бичиг	
4	ВХҮҮ-ийн хувьцааг худалдан авч буй хувьцаа эзэмшигчийн хөрөнгийн гарал үүсэл, түүний нотлох баримт	
5	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахтай холбогдуулан зохицуулалттай этгээдийн дүрэмд орох нэмэлт, өөрчлөлтийн төсөл	

---oOo---

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны ... сарын ...-ны өдрийн ... дугаар тогтоолоор баталсан “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журам”-ын хоёр дугаар хавсралт

ВХҮҮ-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, холбогдох этгээд болон эрх бүхий албан тушаалтанд өөрчлөлт оруулах тухай өргөдөл

Өргөдөл гаргасан огноо	Он		Сар		Өдөр	
Өргөдөл гаргагч хуулийн этгээдийн оноосон нэр						
Улсын бүртгэлийн дугаар						
Регистрийн дугаар						

Дараах төрлөөс сонгоно уу.

- Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах
- Холбогдох этгээдэд өөрчлөлт оруулах
- Эрх бүхий албан тушаалтанд өөрчлөлт оруулах

Хэсэг 1. Хувь нийлүүлсэн хөрөнгө /ХНХ/-ийн хэмжээнд өөрчлөлт оруулах

Овог нэр/ оноосон нэр	РД	Одоогийн ХНХ- ийн хэмжээ (₮)	Нэмэгдсэн (₮)	Хорогдсон (₮)	Өөрчлөлт орсны дараах ХНХ-ийн хэмжээ (₮)	ХНХ-д эзлэх хувь

Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг хувьцаа эзэмшигч бүрээр бичнэ.)

Хэсэг 2. Холбогдох этгээдэд өөрчлөлт оруулах

Овог нэр/ оноосон нэр	Эцсийн өмчлөгч эсэх	ХНХ-ийн 5, түүнээс дээш хувийг эзэмшдэг эсэх	Харьяалал	РД	Хувьцааны тоо (ш)	ХНХ-ийн хэмжээ (₮)	ХНХ-д эзлэх хувь

Хэсэг 3. Эрх бүхий албан тушаалтанд өөрчлөлт оруулах

Албан тушаал	Овог нэр	Харьяалал	РД	Мэргэжил	Утасны дугаар

Өргөдөл гаргасан:

(Эрх бүхий албан тушаалтан)

(гарын үсэг)

(огноо)